



**ХЭНТИЙ АЙМАГ
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 06 сарын 12 өдөр

Дугаар 5/18

Бор-Өндөр

У.Дөлгөөн-Учралыг 1 дүгээр багийн
Зохион байгуулагчийн албан тушаалд
томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.4, 67.5 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.3 дахь заалт, Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт, Засгийн газрын 2024 оны 82 дугаар тогтоолын хавсралт, Засгийн газрын 2022 оны 491 дүгээр тогтоол, Хэнтий аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Бор-Өндөр 1 дүгээр багийн Зохион байгуулагчийн сул орон тоон дээр төрийн алба хаагчийн нөөцөд байгаа иргэн Уланбаярын Дөлгөөн-Учралыг 2024 оны 06 дугаар сарын 12-ны өдрөөс эхлэн уг орон тоог нөхөн томилох хүртэл хугацаагаар томилсугай.

2. Бор-Өндөр 1 дүгээр багийн Зохион байгуулагчийн ажил, эд хөрөнгийг хүлээлгэн өгөх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Ц.Жаргалсайхан

Дотоод ажил хариуцсан мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга:

Б.Цогзолмаа

2 дугаар багийн Зохион байгуулагч

Гишүүн:

М.Юмсүрэнмөнх


Нярав

3. Бор-Өндөр 1 дүгээр багийн Зохион байгуулагч У.Дөлгөөн-Учралын албан тушаалын цалинг төрийн захиргааны албан хаагч, туслах түшмэл ангилал ТЗ-10 буюу

2.//

1,100,000 (нэг сая нэг зуун мянга) төгрөгөөр тооцож, орон нутагт ажилласны нэмэгдлийг 60 хувь, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 3 хувь, хоолны мөнгийг зохих журмын дагуу бодож олгохыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (О.Мөнхцэцэг)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



З.УУГАНЖАРГАЛ